

ОЮУНЫ ӨМЧИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Оюуны өмчийн үндэсний зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Зөвлөл нь төрөөс оюуны өмчийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, оюуны өмчийн эдийн засгийн эргэлтийг дэмжих бодлого боловсруулж, салбар хоорондын уялдааг хангах, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх, аж үйлдвэрийн өмчийн эрхтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Монгол Улсын Олон улсын гэрээнд нийцүүлэх талаар санал боловсруулах түүнийг улсын хэмжээнд зохицуулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна.

1.3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа оюуны өмчийн хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажлын зохион байгуулалт

2.1. Зөвлөл нь Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллана.

2.2. Зөвлөл нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн 10-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлж, бүрэлдэхүүнийг холбогдох байгууллагын удирдлагатай зөвшилцөн батална.

2.3. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хурал байна. Зөвлөлийн дарга хурлыг зарлан хуралдуулж, хурлыг удирдана.

2.4. Зөвлөл нь жилд хоёр удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн дарга ээлжит бус хурал зарлан хуралдуулж болно.

2.5. Зөвлөлийн хурлын материалыг дэд дарга хурал болохоос 3-аас доошгүй өдрийн өмнө гишүүдэд тараасан байна.

2.6. Зөвлөлийн хурлын явцын тухай Зөвлөлийн нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтөлж, Зөвлөлийн даргаар гарын үсэг зуруулна.

2.7. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх зарим асуудлаар салбарын эрдэмтэн, судлаач, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж санал, дүгнэлтийг нь сонсож болно.

2.8. Зөвлөлийн гишүүдийн олонхи оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн саналаар шийдвэр гаргана.

2.9. Зөвлөл нь ажлын албатай байх бөгөөд ажлын албаны үүргийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.

2.10. Ажлын алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.10.1. Оюуны өмчийг хөгжүүлэх төрийн бодлого, тэргүүлэх чиглэл, мастер төлөвлөгөө, үндэсний хөтөлбөр, Засгийн газрын захиалгаар хэрэгжүүлэх оюуны өмчийн төслийн саналыг боловсруулах, батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах;

2.10.2. Оюуны өмчийн эдийн засгийн эргэлтийг дэмжих бодлого боловсруулж, салбар хоорондын уялдааг хангах;

2.10.3. Оюуны өмчийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэх талаар санал боловсруулах;

2.10.4. Зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангаж, хурлыг зохион байгуулах;

2.10.5. Зөвлөлийн хурлын шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, дүн, явцыг Зөвлөлд тайлагнах;

2.10.6. Оюуны өмчийн шилдэг бүтээл шалгаруулж, шагнах;

2.11. Зөвлөлийн дарга хурлаар хэлэлцэх асуудал болон хурлаас гарсан шийдвэрийг баталгаажуулж, шаардлагатай зарим асуудлыг Засгийн газрын хуралдаанаар оруулж шийдвэрлүүлж болно.

2.12. Зөвлөлийн дарга нь зөвлөлийн гишүүдэд үүрэг, даалгавар өгч биелэлтэд нь хяналт тавина.

Гурав. Зөвлөлийн бүрэн эрх

3.1. Зөвлөл нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Оюуны өмчийг хөгжүүлэх төрийн бодлого, үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэж, зөвлөмж гаргах;

3.1.2. Оюуны өмчийг хөгжүүлэх төрийн бодлого, үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцэх;

3.1.3. Оюуны өмчийг хөгжүүлэх, инновацийг нэвтрүүлэх, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох чиглэлээр салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагааг хангах;

3.1.4. Оюуны өмчийг хамгаалах, инновацийг нэвтрүүлэх асуудлаар яам, Засгийн газрын агентлаг, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгжээс ажлын тайлан, мэдээ, судалгаа, дүгнэлт гаргуулах;

3.1.5. Оюуны өмчийн тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр төрөөс баримтлах бодлогод тусгагдсан арга хэмжээний санхүүжилтийг эдийн засаг,

нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.1.6. Шаардлагатай тохиолдолд Засгийн газрын хуралдаанаар асуудлыг хэлэлцүүлж хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх

----oOo----